

"Жуулчин говь" ХК-ийн ТУЗ-ийн

Хурлын тэмдэглэл

2023-04-24

Улаанбаатар хот.

"Жуулчинговь"ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04-р сарын 24-ний өдрийн 13 цагт "Монгол савхи" ХК-ийн танхимд хуралдлаа.

Хурлын дарга: Г.Мөнхбилэг: хурлыг нээж нарийн бичгийн дарга ирцийг илтгэ гэв.

НБДарга:С.Батбилэг ирцийг танилцуулав.

"Жуулчинговь"ХК-ийн хувьцааны 67541 ширхэг хувьцааг эзэмшигч 4 хувьцаа эзэмшигч хуралд хүрэлцэн ирж 71,72 хувийн ирцтэй байна.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

- ✓ Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгох
- ✓ Аудитын хорооны дарга гишүүдийг сонгох
- ✓ Нэр дэвшүүлэх хорооны дарга гишүүдийг сонгох
- ✓ Цалин урамшууллын хорооны дарга гишүүдийг сонгох

Хэлэлцсэн нь: Г.Мөнхбилэг : Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгоё. Гишүүд саналаа хэлээрэй.

Ч.Тогтохбаяр:ТУЗ-ийн даргаар сонгогдон ажиллаж байгааГ.Мөнхбилэг даргыг улируулан сонгох саналтай байна.

Э Мөнхсайхан:Компани болон улсад олон жил ажилласан,мэдлэг туршлага ихтэй тул гишүүдээс гарсан саналыг дэмжинэ.

Г.Мөнхбилэг:За Ч.Тогтохбаярын гарагасан саналаас өөр санал байхгүй бол санал хураая.Санал хураахад хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар Г.Мөнхбилэгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар сонгов.

Г.Мөнхбилэг:Хэлэлцэх асуудлыг дагуу Аудитын хорооны дарга гишүүдийг сонгоё.

Б .Гантулга:Өнгөрсөн жилд сонгогдсон дарга гишүүдийг улируулан сонгомоор байна.Ч.Тогтохбаяр:Жил бүр өөр өөр хүн сонгож байснаас тогтвортой ажиллах хүн байсан дээр. Тиймээс Б. Гантулгын саналыг дэмжиж байна.

Ө.Будханд:Хорооны гишүүдийг сэлгэн ажиллуулах нь зүйтэй Тийм учраас би саналаа хэлье. Хуралдаа бэлтгэлтэй ирж оролцож байна.Цалин урамшууллын хорооны даргаар Ч.Тогтохбаяр, гишүүдээр Э.Мөнхсайхан, А.Цэцэгдэлгэр нар, Аудитын хорооны даргаар А.Цэцэгдэлгэр, гишүүдээр Э.Мөнхсайхан,Ө.Будханд нарыг, Нэр дэвшүүлэх хорооны даргаар Г.Мөнхбилэг, гишүүдээр А.Цэцэгдэлгэр

Э. Мөнхсайхан нарыг сонгох саналтай байна

Г.Мөнхбилэг:За тэгвэл Ө.Будхандын гаргасан саналаар санал хураалт явуулья. Нарийн бичгийн дарга саналын хувийг илтгээрэй.



ТУЗ-ийн гишүүн Ө.Будхандын гаргасан саналыг хуралд оролцсон гишүүд 100 хувь дэмжсэн байна .

Г.Мөнхбилэг: Өөр саналтай хүн байхгүй байна Санал хураахад оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар хороодын дарга гишүүдийг сонгов.

Г.Мөнхбилэг: Хурлын шийдвэрийг танилцуулав.

1.Хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар Г.Мөнхбилэгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар сонгов.

2.Хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар Аудитын хорооны даргаар А. Цэцэгдэлгэр, гишүүдээр Э. Мөнхсайхан, Ө.Будханд нарыг сонгов.

3.Хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар Цалин урамшууллын хорооны даргаар Ч.Тогтохбаяр, гишүүдээр Э. Мөнхсайхан, А. Цэцэгдэлгэр нарыг сонгов.

4.Хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар Нэр дэвшүүлэх хорооны даргаар Г.Мөнхбилэг, гишүүдээр А.Цэцэгдэлгэр Э. Мөнхсайхан нарыг сонголоо.

Хурлыг 15 цаг 30 минутанд хаав.

Хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүд:



Г.Мөнхбилэг


Ч.Тогтохбаяр


А. Цэцэгдэлгэр

Э. Мөнхсайхан,

Ө .Будханд


Г.Мөнхбилэг

Ч.Тогтохбаяр

А.Цэцэгдэлгэр

Э.Мөнхсайхан

Ө.Будханд

Тэмдэглэл хөтөлсөн  С.Батбилэг